



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 5/03

Ховд

Ш.Нохойжавыг ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.16, 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2022 оны А/79 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газраас хянагдаж ирэх хүртэл хугацаанд "Шугам сүлжээ, орон сууц ашиглалтын газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргаар Ширнэнгийн Нохойжавыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. Ш.Нохойжавд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-ний ТҮ-12 дахь шатлалтай дүйцүүлж буюу 995822 (есөн зуун ерэн таван мянга найман зуун хорин хоёр) төгрөгөөр цалинжуулж, холбогдох нэмэгдлүүдийг хуульд заасны дагуу тооцон олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

3. Тус газрын нэршил, бүтэц, дүрэмд орсон өөрчлөлт оруулан улсын бүртгэлд бүртгүүлж ажиллахыг "Шугам сүлжээ, орон сууц ашиглалтын газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (Ш.Нохойжав)-д үүрэг болгосугай.

4. "Шугам сүлжээ, орон сууц ашиглалтын газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баярсүх)-д даалгасугай.

᠑᠘᠐᠒᠒᠒1 ᠒᠒85

Zah B/03 Ba

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны 148 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Э.БОЛОРМАА